

# Гялтганасан ЗҮҮЛТ

Каролина зүүлтийг дахиад жаахан хадгалмаар байлаа.



**Каролина Марин**  
(Бодит түүхээс сэдэвлэв)

Энэ түүх Аргентинд болсон юм.

Каролина гадаа талбайдаа дэгдэн гүйж байв. Түүний найз Изабелла гадаа байсан ба “Ирээд, тоглооч!” гээд даллав.

Каролина Изабеллагийн гэрийн гадаа талбайд очив.

Изабелла халаасаа уудлаад, “Би чамд нэг юм үзүүлмээр байна” гэв. Тэгээд тэр Каролинагийн урд өмнө харж байгаагүй хамгийн үзэсгэлэнтэй зүүлтийг гаргаж ирэв! Жижиг эрдэнийн чулуунууд нь үнэхээр гялтганасан, тод байлаа.

“Энэ миний ээжийн зүүлт. Тэр намайг өнөөдөр үүгээр тоглож болно гэсэн. Наранд хараад үз дээ” гэж Изабелла хэлэв.

Изабелла зүүлтийг гэрэлд барилаа. Хэдэн зуун солонго эрдэнийн чулуунаас цацарсан ба үнэхээр үзэсгэлэнтэй байлаа!

“Одоо нуугдаж тоглоцгооё!” гэж Изабеллаг хэлэхэд,

“Тэгье!” гэж Каролина хариулав. “Би зүүлтийг чинь хадгалж чадна” гэхэд,

“Баярлалаа!” гээд Изабелла зүүлтээ Каролинад өгөөд, Каролина зүүлтийг халаасандаа хийлээ.

Удалгүй Каролинагийн гэртээ харих цаг боллоо. Каролина баяртай гэж хэлэхэд Изабелла зүүлтийн талаар асуусангүй. Тэр мартчихсан байв. Каролина ч мөн түүнд сануулсангүй.

Каролина зүүлтийг гэр лүүгээ авч явсандаа санаа нь зовж байлаа. Гэсэн ч тэр зүүлтийг дахиад жаахан хадгалмаар байв. Тэр муухай мэдрэмжээ тоолгүй зүүлтийг дэрэн дороо хийв.

Маргааш нь бямба гараг байлаа. Каролина гэрийн ажлаа хийчхээд гадаа тоглохоор гарчээ. Тэр зүүлтийн талаар таг мартсан байлаа.

“Каролина! Чи хүрээд ирээч” гэж аав нь дуудахад,

“За” гээд Каролина дотогш гүйн орлоо.

Аав нь гартаа зүүлт барьсан байв. “Ээж чинь үүнийг чиний дэрэн дороос оллоо. Энэ хэнийх юм бэ?” гэж аав нь асуулаа.

“Изабеллагийнх” гээд Каролина нулимс дуслуулав. “Өчигдөр хамт тоглож байхдаа би үүнийг халаасандаа хийсэн юм. Тэгээд би гэртээ аваад ирчихсэн.”

Ээж нь Каролинатай хамт буйдан дээр суугаад, “Үнэнээ хэлсэнд баярлалаа. Чи одоо юу хийх хэрэгтэй гэж бодож байна?” гэв.

Каролина юм дуугарсангүй. Тэр Есүсийн тухай бодож байв. Тэр Каролинаг шударга байж, зүүлтийг буцааж өгөхийг хүсэх байсан.

“Би үүнийг Изабеллад буцааж өгөөд уучлал гуйх хэрэгтэй” гэж Каролина хэлэв. Ингэж хэлмэгц нөгөөх муухай мэдрэмж алга болов. Тэр зүрх сэтгэлдээ дулаан зүйлийг мэдрэв.

Каролина Изабеллагийн гэр лүү явлаа.

Каролина “Сайн уу?” гээд, зүүлтийг Изабеллад өгөв. “Зүүлтийг чинь авсанд уучлаарай. Чи намайг уучлах уу?”

“Тийм ээ, буцааж өгсөнд баярлалаа” гээд Изабелла инээмсэглэн, “Дахиад нуугдаж тоглох уу?” гэв.

“Тэгье! Чи эхлээд тоол, би нуугдъя!”

Тэр орой Каролина залбирав. “Хайрт Тэнгэрлэг Эцэг минь, тэр

зүүлтийг авсанд намайг уучлаач. Бас алдаагаа засахад минь тусалсанд баярлалаа.”

Каролина зүрх сэтгэлдээ дулаан мэдрэмжийг дахин мэдрэв. Есүс байсан бол түүнийг хийгээсэй гэж хүссэн зүйлийг хийсэндээ тэр баяртай байлаа. ●

## БИ НАМАНЧИЛЖ ЧАДНА

Бид бүгд заримдаа буруу сонголт хийдэг. Есүс Христ болон Түүний Цагаатгалын ачаар бид үүнийг өөрчилж, алдаагаа засаж чадна. Үүнийг наманчлах гэж нэрлэдэг. Бид наманчлах үедээ гомдоосон хүмүүсээсээ уучлал гуйдаг. Бид алдаагаа засахыг хичээдэг. Бид өршөөл эрэн залбирдаг. Бид дахин буруу сонголт хийхгүй байхыг хамгийн сайнаараа хичээдэг. Тэгээд Тэнгэрлэг Эцэг биднийг өршөөж, амар амгаланг мэдрүүлдэг.

